



Агуулга

I.Оршил

I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт4

I.2.Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь8

II.Мал аж ахуй

II.1.2017 оны мал тооллогын дүн10

II.2 .Малын хэрэглээний зарлага19

II.3.Төл бойжилт20

II.4.Том малын зүй бус хорогдол23

II.5. Малын хулгай26

II.6.Иргэдийн малын бүлэглэлт27

II.7.Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж27

II.8.Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт29

II.9.Малчдын тоо, насны бүлгээр30

II.10.Малтай өрх, малчин өрх31

III.Газар тариалан

III.1.Тариалсан талбай32

III.2.Хураасан ургац33

IV.Дүгнэлт



Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Д.Жавзанлхам

Санал хүсэлт байвал доорх

Хаягаар холбоо барина уу.

Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс

Засаг даргын тамгын газрын байр

E-mail: Darkhan-uul.nso.mn

Утас:70377031 70377763

Интернет хаяг://Darkhan-uul.nso.mn/

Дархан-Уул аймаг Статистикийн хэлтэс

Дархан хот 2018



ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр үрийн сорт, байгаль цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2017 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг “ –ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь аймгийн удирдлага, нутгийн захиргааны байгууллагад тархааж, аймгийн түвшинд бодлого боловсруулах, төсөл хөтөлбөрийн мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2017 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Малын 2017 оны тооллогын маягт ҮСХ-ны даргын 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан маягтаар, зааврын дагуу явуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад малын 2017 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэхээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, шинээр гаргасан, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.



Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар 2016 онд ДНБ-ий 10.4 хувийг үйлдвэрлэж, 2010 оноос хойш үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

I.1.Нэр томьёоны товч тайлбар, тодорхойлолт

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.



Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод

1 тэмээ -1.5 бод

6 хонь – 1 бод

8 ямаа -1 бод Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1тэмээ -5 хонь

1 адуу-7 хонь

1үхэр -6 хонь

1 хонь-1 хонь

1 ямаа-0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр -2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал- тухайн жилийн төл малаас бусад насны мал



Өсвөр насны мал

Тэмээ –өмнөх оны төл 2,3 настай

Адуу-Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **Орлого тал** нь төл бойжилт, **Зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь: Буур 20-25, Азарга 12-15, Бух 35-45, Хуц, Ухна 25-30



Том малын зүй бус хорогдолд Өвчний /халдвартай, халдваргүй/ хорогдол, гэнэтийн аюулын /Цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг / хорогдол, бусад шалтгааны /малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан/ хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага Оны эхний малын тоо дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж Тэжээлийн хамгамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилүүлж тэжээлийн хамгамжийг гаргана. Үүний тулд: Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал -0.25, Гар тэжээл хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал 0.22, Үр тарианы хаягдал 0.90, Лай -0.40, Сүрэл -0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.



Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл –өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл –үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл –Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил орно.

- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ

Га-гийн ургац Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын / хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлоно.

Нийт ургац Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.



I.2.ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2017 онд цаг агаарын байдал олон жилийн дундажтай ойролцоо, мал төллөлтийн 80.2 хувь, төл бойжилтын хувь 95.6 хувьтай болж 2017 оны мал тооллогын дүнгээр 310939 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 13224 толгой, малаар буюу 4.1 хувиар буурсан.


Аймгийн ДНБ болон ХАА-н салбарын эзлэх хувь хэмжээ /сая.төг/

Хүснэгт1

	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
							зөрүү
Бүгд	305144.0	362087.7	367262.7	387260.4	437804.2	113.1%	50543.8
ХАА, ойн аж ахуй, ан агнуур	38143.0	42364.3	35991.7	37564.3	34148.7	90.9%	3415.6
ДНБ-ний дүндээ эзлэх хувь	12.5	11.7	9.8	9.7	7.8	0.8про	1.9

Зураг1

ХАА, ойн аж ахуй, ан агнуур /сая.төг/ ДНБ-ний дүндээ эзлэх хувь 2015-2017



**II.2017 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН****II.1.МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ**

Малын тоо. 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 310.9 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 4.1 хувиар буюу 13224 толгойгоор буурсан. Үүнд тэмээ 57 толгой, хонь 11340 толгой, ямаа 3162 толгойгоор тус тус хорогдож, адуу 47 толгой, үхэр 1288 толгойгоор нэмэгдсэн. Өнгөрсөн онтой харьцуулахад Дархан сум 4.6 хувь буюу 3306 толгой, Хонгор сум 2.4 хувь буюу 3963 толгой, Орхон сум 2.8 хувь буюу 1150 толгой, Шарын гол 11.3 хувь буюу 4805 толгойгоор тус тус буурсан байна.

МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР**Хүснэгт2**


	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
						%	зөрүү
Бодоор/мян.тол/	86.7	100.7	96.1	105	104.1	99.1	-0.9
Толгойн тоо	279053	324241	288363	324163	310939	95.9	-13224
Тэмээ	185	89	73	95	38	40.0	-57
Адуу	12812	14173	14726	16949	16996	100.3	47
Үхэр	39240	46601	46933	49003	50291	102.6	1288
Хонь	144924	167617	143597	162178	150838	93.0	-11340
Ямаа	81892	95761	83034	95938	92776	96.7	-3162

МАЛЫН ТОО, СУМААР**Хүснэгт3**

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	68954	26	4203	14969	29542	20214
Хонгор	163955	0	8422	18584	87646	49303
Орхон	40315	12	2249	10842	15490	11722
Шарын гол	37715	0	2122	5896	18160	11537
ДҮН	310939	38	16996	50291	150838	92776



МАЛЫН ТОО,УЛС,АЙМАГ МЯН.ТОЛГОЙ, 2015-2017 ОН Зураг2



2017 онд улсын хэмжээнд нийт 66218.96 мянган толгой мал тоологдсоны 0.5 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс тэмээ 0.009 хувь, адуу 0.4 хувь, үхэр 1.15 хувь, хонь 0.5 хувь, ямаа 0.3 хувийг тус тус эзэлж байна.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ /мян.тол/

Хүснэгт4

	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо /Улсын дүнгээр/			Улсын дүнд эзлэх %		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
Бодоор	96.0	105.0	104.1	14427.4	15823.6	17416.0	0.7	0.7	0.6
Толгойн тоо	288.4	324.2	310.9	55979.8	61549.2	66219.0	0.5	0.5	0.5
Тэмээ	0.1	0.1	0.0	368.0	401.3	434.1	0.0	0.0	0.0
Адуу	14.7	16.9	17.0	3295.3	3635.5	3939.8	0.4	0.5	0.4
Үхэр	46.9	49.0	50.3	3780.4	4080.9	4388.5	1.2	1.2	1.2
Хонь	143.6	162.2	150.8	24943.1	27856.6	30109.9	0.6	0.6	0.5
Ямаа	83.0	95.9	92.8	23592.9	25574.9	27346.7	0.4	0.4	0.3



ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Хүснэгт5

	2013	2014	2015	2016	2017	2017/2015		2017/2016	
						%	өсөлт	%	өсөлт
Малтай өрхийн тоо	2476	2467	2408	2501	2531	105.1	123	101.2	30
Бодоор	84620	98934	94480	103879	103244	109.3	8764	99.4	-635
Толгойн тоо	270013	316810	283103	319841	307897	108.8	24794	96.3	-11944
Тэмээ	185	89	73	95	38	52.1	-35	40.0	-57
Адуу	12601	13925	14494	16726	16812	116.0	2318	100.5	86
Үхэр	38856	46104	46322	48668	50051	108.1	3729	102.8	1383
Хонь	137858	162231	140135	159060	148792	106.2	8657	93.5	-10268
Ямаа	80513	94461	82079	95292	92204	112.3	10125	96.8	-3088

НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Хүснэгт6

	2012	2013	2014	2015	2016	2017
Тэмээ	0.2	0.1	0.0	0.03	0.03	0.01
Адуу	4.2	4.6	4.4	5.1	5.2	5.5
Үхэр	13.3	14.1	14.4	16.3	15.1	16.2
Хонь	50.7	51.9	51.7	49.8	50.0	48.5
Ямаа	31.7	29.3	29.5	28.8	29.6	29.8
Бүгд	100	100	100	100	100	100


2017 оны малын тоо толгойн буурхад нь үндсэндээ хонь, ямаан сүргийн тоо нь буурсан нь нөлөөлсөн байна.

Нийт малын сүргийн бүтцээс харвал 48.5 хувийг хонь, 29.8 хувийг ямаа, 16.2 хувийг үхэр, 5.5 хувийг адуу 0.01 хувийг тэмээ тус тус эзэлж байна.



НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2017 ОН

Зураг3



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Хүснэгт7

	2013	2014	2015	2016	2017
Бүгд	133821	152747	138911	155424	152988
Ингэ	90	34	26	43	16
Гүү	3905	4460	4568	5536	5926
Үнээ	16809	20544	19995	21796	22017
Эм хонь	72869	81777	72536	81307	78056
Эм ямаа	40148	45932	41786	46742	46973

Хээлтэгч мал нийт малын 49.2 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 42.1 хувь, адуун сүргийн 34.9 хувь, үхэр сүргийн 43.8 хувь, хонин сүргийн 51.7 хувь, ямаан сүргийн 50.6 хувийг тус тус эзэлж байна.



Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50-55 хувь, бог малын хувьд сүргийн 60-65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 41.5, бог малд 51.5 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

Хүснэгт8

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	52.0	47.7	48.4	48.0	47.1	48.2	47.9	49.2
Ингэ	36.8	52.9	44.9	48.6	38.2	35.6	45.3	42.1
Гүү	31.1	30.8	30.6	30.5	31.5	31.0	32.7	34.9
Үнээ	45.4	45.5	43.6	42.8	44.1	42.6	44.5	43.8
Эм хонь	53.4	50.0	50.6	50.3	48.8	50.5	50.1	51.7
Эм ямаа	55.3	47.2	49.1	49.0	48.0	50.3	48.7	50.6

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ

Хүснэгт9

Сумын нэр	2015	2016	2017	Үүнээс					Оны эхний хээлтэгчид эзлэх %	Өмнөх оноос зөрүү +/-
				Ингэ	Гүү	Үхэр	Эм хонь	Эм ямаа		
Дархан	2222	3443	4737	6	322	941	1809	1659	13.7	1294
Хонгор	2162	4348	8105	0	593	738	3032	3742	9.8	3757
Орхон	1170	2013	2922	2	209	534	1263	914	15.9	909
Шарын гол	1417	3188	4051	0	227	531	1669	1624	20.3	863
ДҮН	6971	12992	19815	8	1351	2744	7773	7939	12.7	6823



ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

Хүснэгт10

Малын төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/ 2016
										%
ДҮН	1190	2499	1474	2997	10357	671	1622	1038	4989	4 дах
Ингэ	1	2	3	0	28	0	2	0	0	0.0
Гүү	113	300	50	112	385	11	34	92	322	3 дах
Үнээ	64	640	97	142	1679	58	125	83	292	3дах
Эм хонь	368	4542	610	1000	4712	193	455	216	1519	7дах
Эм ямаа	644	6571	714	1743	3553	409	1006	647	2856	4дах

Оны эхний төллөх насны хээлтэгч малын 3.2 хувьтай тэнцэх 4989 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо өмнөх оноос 3951 толгойгоор буюу 4 дахин нэмэгдсэн байна.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 25.2 хувь буюу 4989 хээл хаясан хээлтэгч, үлдсэн 74.8 хувь буюу 14826 сувайрсан хээлтэгч байна.


СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

Хүснэгт11

Малын төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017 /2016
										%
ДҮН	3150	12935	7837	6317	2651	5364	5348	11947	14826	124.1
Ингэ	0	2	20	31	0	1	9	3	8	266.7
Гүү	348	412	226	341	99	343	400	566	1029	181.8
Үнээ	718	1899	1147	1116	128	1526	1546	2967	2452	82.6
Эм хонь	933	5681	3777	2799	1086	1857	1740	5599	6254	111.7
Эм ямаа	1151	4941	2667	2030	1338	1637	1653	2812	5083	180.8



Зураг4



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

Хүснэгт12

Малын төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016
										%
ДҮН	2689	1945	2147	2059	2151	2463	2561	2461	2159	87.7
Буур	13	12	9	8	5	3	4	1	1	100.0
Азарга	396	378	415	414	464	494	534	605	645	106.6
Бух	384	325	351	328	376	484	522	489	418	85.5
Хуц	1107	773	835	797	801	925	994	895	670	74.9
Ухна	789	457	537	512	505	557	507	471	425	90.2

2017 онд 2159 толгой хээлтүүлэгч мал тоологдож өмнөх оноос 12.3 хувь буюу 302 толгойгоор буурсан байна.



НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Хүснэгт13

Малын төрөл	Үржлийн норм	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/ 2016%
Ингэ	20-25	14	22	30	24	18	11	7	43	16	37
Гүү	12-15	8	8	8	8	8	9	9	9	9	100
Үнээ	35-45	42	45	44	47	45	42	38	44	52	118
Эм хонь	25-30	77	88	75	86	91	88	73	90	116	129
Эм Ямаа	25-30	82	95	76	82	80	82	82	99	110	111

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 116 эм хонь, ямааны хувьд 110 ногдож байгаа нь 3.6-4.6 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ


Хүснэгт14

	Мянган толгойгоор			Хувиар			Толгой	Хувь
	2015	2016	2017	2015	2016	2017	2017 /2016	2017 /2016
Бүгд	288.4	324.2	310.9	100.0	100.0	100.0	-13.3	95.9
Төл өсвөр насны	102.7	117.7	101.1	35.6	36.3	32.5	-16.6	85.9
Ажлын ба бэлтгэл насны	44.2	48.6	54.6	15.3	15.0	17.6	6.0	112.3
Хээлтэгч	138.9	155.4	153.0	48.2	47.9	49.2	-2.4	98.5
Хээлтүүлэгч	2.6	2.5	2.2	0.9	0.8	0.7	-0.3	88.0



СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2017 ОН

Зураг5



МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2017 ОН

Хүснэгт15

	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	Хээлтүүлэгч	БҮГД
Дархан	100.0	32.3	16.2	50.7	0.7	69.0
Хонгор	100.0	32.0	18.0	49.4	0.7	163.9
Орхон	100.0	34.3	16.5	48.4	0.8	40.3
Шарын гол	100.0	33.6	19.3	46.5	0.7	37.7
ДҮН	100.0	32.5	17.6	49.2	0.7	310.9



2017 оны байдлаар нийт малын 32.5 хувь буюу 101.1 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 17.6 хувь буюу 54.6 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 49.2 хувь буюу 153.0 мянган толгой нь хээлтэгч мал, 0.7 хувь буюу 2.2 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

II.2.МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

2017 онд оны эхний нийт малын 35.0 хувьтай тэнцэх 113515 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2016 оныхоос 29351 толгой буюу 34.9 хувиар өссөн байна. Малтай нэг өрхийн дундажаар 45 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 3 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Оны эхний тэмээний 75.7 хувь, адууны 19.6 хувь, үхрийн 28.1 хувь, хонины 40.6 хувь, ямааны 30.6 хувийг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 84.9 хувийг бог мал, 15.1 хувийг бод мал эзэлнэ. Сумаар авч үзвэл малаа хэрэглээндээ хамгийн ихээр зарцуулсан Хонгор сум 58.5 мянган толгой, Дархан сум 29.3 мянган толгой, Шарын гол сум 17.0 мянган толгой, Орхон сум 8.6 мянган толгойг тус тус зарцуулав.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Хүснэгт16

Сумдын нэр	2015	2016	2017	Үүнээс				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	37634	16128	29339	12	1582	4292	14341	9112
Хонгор	99153	46678	58534	11	1055	5606	38333	13529
Орхон	17403	10260	8630	49	298	1842	3952	2489
Шарын гол	16860	11098	17012	0	382	2053	9165	5412
ДҮН	171050	84164	113515	72	3317	13793	65791	30542



Хүснэгт 17


Сумдын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2017/2016	
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	%	зөрүү
Дархан	40.6	35.30	33.9	29.6	45.1	42.9	181.9	13211
Хонгор	34.9	100.00	13.3	30.8	41.3	27.7	125.4	11856
Орхон	20.8	98.00	13.5	18.4	23.4	20.2	84.1	-1630
Шарын гол	40.0	0.00	17.6	32.8	44.4	40.1	153.3	5914
ДҮН	35.0	75.80	19.6	28.1	40.6	31.8	134.9	29351

II.3.ТӨЛ БОЙЖИЛТ

2017 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 80.2 хувь буюу 124638 эх төллөж гарсан төлийн 95.6 хувийг буюу 119366 төл бойжуулав. Бойжуулсан төлийн тоо 2016 оныхоос 2129 толгойгоор буюу 1.8 хувиар өссөн байна.

Бойжуулсан төл, сумаар, /толгой/

Зураг 6





Бойжуулсан төл, толгойгоор, олон жилээр

Хүснэгт 18

Онууд	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
2000	60430	9	1981	8932	33259	16249
2009	145372	104	2190	12163	73815	57100
2010	85969	115	2076	10575	45115	28088
2011	112662	141	2440	12517	60121	37443
2012	115756	111	2825	14389	60071	38360
2013	119492	88	2987	13725	66042	36650
2014	128383	38	3511	15605	70421	38808
2015	138896	20	3776	17353	77170	40577
2016	121495	14	3398	14535	64316	39232
2017	119366	19	3959	17455	64163	33770
2017/2016	98.2	135.7	116.5	120.1	99.8	86.1
Зөрүү	-2129	5	561	2920	-153	-5462

ТӨЛ БОЙЖИЛТ, СУМААР, ТАВАН ТӨРЛӨӨР, 2017 ОН

Хүснэгт 19

Сумын нэр	Бүгд	ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ					Бүгд	ХОРОГДСОН ТӨЛ				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Дархан	29956	4	1245	5250	14137	9320	706	0	24	104	329	249
Хонгор	66120	0	1853	7034	39481	17752	2862	0	47	145	1839	831
Орхон	13809	15	554	3557	5419	4264	1023	0	19	85	357	562
Шарын гол	14753	0	410	1988	8134	4221	879	0	13	41	613	212
ДҮН	124638	19	4062	17829	67171	35557	5470	0	103	375	3138	1854



Хүснэгт20

Сумын нэр	Бүгд	БОЙЖУУЛСАН ТӨЛ					Төллөлтийн хувь	Бойжилтын хувь	ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕ		
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа			Төлийн хорогдол	Урьд онтой харьцуулсан %	Урьд оноос зөрүү /+-/
Дархан	29285	4	1221	5146	13816	9098	86.7	97.6	45	15дах	-661
Хонгор	63258	0	1806	6889	37642	16921	80.0	95.7	66	43 дах	-2796
Орхон	12852	15	535	3473	5093	3736	75.4	92.6	3	341дах	-1020
Шарын гол	13971	0	397	1947	7612	4015	74.1	94.1	324	2.7дах	-555
ДҮН	119366	19	3959	17455	64163	33770	80.2	95.6	438	12дах	-5032

100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

Хүснэгт21

	2000	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017 /2016
БҮГД	73	90	51	87	95	90	96	91	88	76	86.4
Ботго	30	54	61	53	41	45	42	59	54	44	81.5
Унага	52	81	66	77	84	83	90	85	74	71	95.9
Тугал	63	92	66	85	83	86	93	85	73	80	109.6
Хурга	75	92	53	88	96	94	97	94	89	78	87.6
Ишиг	79	88	43	86	94	86	97	88	94	72	76.6

Гарсан ботго 100 хувь, унаганы 97.5 хувь, тугалын 97.9 хувь, хурганы 95.3 хувь, ишигний 94.8 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой




харьцуулахад ботго 35.7 хувь буюу 5 толгой, унага 16.5 хувь буюу 561 толгой, тугал 20.1 буюу 2920 толгойгоор тус тус өсч, хурга 0.2 хувь буюу 153 толгой, ишиг 13.9 хувь буюу 5462 толгойгоор тус тус буурсан байна.

2000 онд 100 эхээс 73 төл бойжуулж байсан бол 2009 онд үүнээс 17 төлөөр, 2011 онд 14 төлөөр, 2012 онд 22 төлөөр, 2017 онд 3 төлөөр буюу 4.1 хувиар өсөж, харин өмнөх онтой 12 төлөөр буурсан байна 100 эх малаас 76 төл авсан байна.

Таван төрлөөр авч үзэхэд өмнөх оныхоос ботго 5 төл буюу 18.5 хувиар, унага 3 төл буюу 4.1 хувиар, хурга 11 төл буюу 12.4 хувь, ишиг 22 төл буюу 23.4 хувиар тус тус буурч байна. тугал 7 төл буюу 9,6 хувиар өссөн байна.

II.4.Том малын зүй бүс хорогдол

Зураг7



2017 онд оны эхний нийт малын 5.9 хувьтай тэнцэх 19075 толгой мал хорогдсон нь 2016 оныхоос 17458 толгойгоор буюу 1100 дахин өссөн байна. Нийт хорогдсон малын 34.5 хувийг ямаа, 50.9 хувийг хонь, 12.4 хувийг үхэр, 3.1 хувийг



адуу, 0.02 хувийг тэмээ эзэлж байна. Өвчнөөр 114 толгой мал хорогдсон нь нийт хорогдолын 0.6 хувийг эзэлж, 6921 толгой хээлтэгч мал хорогдсон нь нийт хорогдолын 36.3 хувийг тус тус эзэлнэ.

ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ

Хүснэгт22

	Өвчнөөр хорогдсон, бүгд				Зүй бус хорогдолд эзлэх хувь			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Тэмээ	0	0	1	0	0	0	0.06	0
Адуу	4	3	3	0	4.2	0.08	0.2	0
Үхэр	22	13	14	3	10.8	0.3	0.9	0.1
Хонь	72	32	296	99	7.7	0.9	18.3	1
Ямаа	16	16	14	12	4.1	0.4	0.9	0.2
БҮГД	114	64	328	114	6.9	1.7	20.3	0.6

2017 ОНЫ ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, СУМААР

Хүснэгт22

Сумын нэр	Хорогдол Бүгд	Үүнээс					2016 оны хорогдол	Оны эхний малд эзлэх
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
Дархан	3252	0	96	382	1750	1024	245	4.5
Хонгор	8687	0	250	923	4520	2994	602	5.2
Орхон	5372	4	191	813	2539	1825	213	13
Шарын гол	1764	0	58	256	903	547	557	4.1
ДҮН	19075	4	595	2374	9712	6390	1617	5.9



Зүй бусаар хорогдсон малын тоог сумдаар авч үзвэл Дархан, Хонгор, Орхон Шарын гол сумын хорогдол өсч аймгийн хэмжээний хорогдлын дүн өсөхөд нөлөөлсөн болно.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Хүснэгт23

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	46122	2287	2122	3426	1645	3724	1617	19075
Тэмээ	34	36	20	33	21	2	5	4
Адуу	438	100	151	191	96	141	89	595
Үхэр	4151	211	381	513	204	620	340	2374
Хонь	19142	971	902	1505	930	1843	825	9712
Ямаа	22357	969	668	1184	394	1118	358	6390

ОНЫ ЭХНИЙ МАЛД ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Хүснэгт24


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017 /2016
Бүгд	18.5	0.9	0.8	1.3	0.6	1.1	0.6	5.9	983.3
Тэмээ	4.7	7.1	4.6	7.6	11.4	2.2	6.8	4.2	61.8
Адуу	4.3	0.9	1.3	1.7	0.7	1.0	0.6	3.5	583.3
Үхэр	12.8	0.6	1.1	1.4	0.5	1.3	0.7	4.8	685.7
Хонь	15.0	0.8	0.7	1.1	0.6	1.1	0.6	6.0	1000.0
Ямаа	28.4	1.1	0.8	1.4	0.5	1.2	0.4	6.7	1675.0



II.5 МАЛЫН ХУЛГАЙ

Малын хулгай 2011-2017 он

Зураг8



2017 онд 303 толгой мал хулгайд алдаж, өмнөх оныхоос 40.8 хувиар буурсан байна.

**II.6. ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ**

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

Хүснэгт 25

	Малтай өрхийн тоо			Дүнд эзлэх хувь			Малын тоо		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
10 хүртэлх малтай	726	740	728	30.1	29.6	28.8	4038	4097	4022
11-30 малтай	483	463	500	20.1	18.5	19.8	8916	8618	9233
31-50 малтай	213	220	192	8.8	8.8	7.6	8409	8647	7499
51-100 малтай	284	290	324	11.8	11.6	12.8	20446	21316	23336
101-200 малтай	256	281	319	10.6	11.2	12.6	36347	40536	45886
201-500 малтай	305	344	313	12.7	13.8	12.4	96996	110559	101946
501-999 малтай	119	131	136	4.9	5.2	5.4	81496	89703	93994
1000-1499 малтай	21	31	18	0.9	1.2	0.7	24490	34495	20332
1500-2000 малтай	1	1	1	0.0	0.04	0.04	1965	1870	1649
2000 дээш малтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0
ДҮН	2408	2501	2531	100.0	100.0	100.0	283103	319841	307897

Мал бүхий 2531 өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл, 28.8 хувь буюу 728 өрх нь 10 хүртэл малтай: 19.8 хувь нь буюу 500 өрх нь 11-30 малтай: 7.6 хувь буюу 192 өрх нь 31-50 малтай: 12.8 хувь буюу 324 өрх нь 51-100 малтай: 12.6 хувь буюу 319 өрх нь 101-200 малтай: 12.4 хувь буюу 313 өрх нь 201-500 малтай: 5.4 хувь буюу 136 өрх нь 501-999 малтай: 0.7 хувь буюу 18 өрх нь 1000-1499 малтай; 0.04 хувь буюу 1 өрх нь 1500-2000 малтай өрх байна.

II.7. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж,

2017 онд аймгийн хэмжээгээр 17995.7 тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 57.3 хувь буюу 13392.1 тонноор буурсан.



Тэжээл бэлтгэл /тн/

Хүснэгт26

	2013	2014	2015	2016	2017	2017/2016
Н	55043	61660	59014.4	64522.3	33713.8	52.3
с	31.9	31.7	163.1	139.0	26.2	18.8
үү	561.2	186.5	56.8	349	16.5	4.7
М	817.7	244	809.2	917.6	1015.1	110.6
с	200	270.2	116.7	124.6	161.5	129.6
ш	561.2	594.9	1451.8	1266.6	1391.1	109.8
и	0	77.1	30.3	48.6	17	0.0
	61.8	38.3	171.5	41.7	135.5	324.9
ш (, ү)	26259.1	28684	28824.3	31387.8	17995.7	57.3

с

Хүснэгт27

	2013	2014	2015	2016	2017	2017/ 2016%
ш (, ү)	26259.1	28684.0	28824.3	31387.8	17995.7	57.3
к ү /н ш	544.7	633.1	603.4	661.7	655.2	99.0
Н ш, ш, ш	48.2	45.3	47.8	47.4	27.5	58.0

**II.8. Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт**

Малчдын ахуй, соёлын зарим үзүүлэлт, өрхийн тоогоор, жилээр

Хүснэгт 28

	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Цахилгаантай	901	1005	1166	1066	1161	1068	95.9	98.5	100.0	96.9	97.3	77.9
Телевизортой	742	928	1125	1001	1028	975	78.9	91.0	96.5	91.0	86.2	71.1
Автомашинтай	730	853	706	993	862	894	77.7	83.6	60.5	90.3	72.3	65.2
Мотоцикльтой	236	302	330	319	363	312	25.1	29.6	28.3	29.0	30.4	22.8
Худагтай	438	465	680	561	788	625	46.6	45.6	58.3	51.0	66.1	45.6

2017 оны тооллогоор нийт малчин өрхийн 89.5 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 81.7 хувь нь телевизортой, 74.9 хувь нь авто машинтай, 26.2 хувь нь мотоцикльтой, 52.4 хувь нь худагтай гэсэн дүн гарсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад малчдын ахуйн үзүүлэлт болох цахилгаантай, телевизортой, мотоцикльтой, худагтай өрхийн тоо буурч, автомашинтай өрхийн тоо 3.7 хувиар нэмэгдсэн байна.



МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР

Хүснэгт29

		Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
										хувь	зөрүү
Малтай өрх		тоо	2752	2412	2476	2467	2408	2501	2531	101.2	30
Малчин өрх		тоо	1316	940	1020	1166	1100	1193	1371	114.9	178
Малчдын тоо		тоо	3784	1837	1972	2223	2108	2279	2293	100.6	14
Үүнээс:	16-34 насны	хүн	981	577	592	586	546	604	586	97.0	-18
	35-аас тэтгэврийн нас хүртэл	хүн	1986	1037	1132	1350	1327	1390	1298	93.4	-92
	Тэтгэвэрийн насны	хүн	817	223	248	287	235	285	409	143.5	124
Нийт малчдаас эмэгтэй		хүн	1673	804	948	1060	995	1050	985	93.8	-65
Насны бүтэц хувь		%	100	100	100	100	100	100	100	-	0
Үүнээс:	16-34 насны	%	25.9	31.4	30	26.4	25.9	26.5	25.6	-	-0.9
	35-аас тэтгэврийн нас хүртэл	%	52.5	56.4	57.4	60.7	63	61	56.6	-	-4.4
	Тэтгэвэрийн насны	%	21.6	12.1	12.6	12.9	11.1	12.5	17.8	-	5.3

II.9.МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮЛГЭЭР

Хүснэгт 30

Эмэгтэй малчид	16-34			35-59			Эмэгтэй малчид
	16-34	35-54	55-59	35-54	55-59	60-64	
840	387	612	173	320	119	270	
806	581	1016	272	581	163	416	
463	259	411	95	245	71	168	
422	144	254	46	152	56	131	
2531	1371	2293	586	1298	409	985	



Аймгийн хэмжээгээр 2017 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 2531 өрх тоологдсон байна. Үүний 54.2 хувь буюу 1371 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 45.8 хувь буюу 1160 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2017 онд дүнгээр 2297 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 25.6 хувь нь 16-34 настай, 56.6 хувь нь 35-59 насны 17.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Малчин өрхийн тоог өмнөх онтой харьцуулахад 14.9 хувь буюу 178 өрхөөр өссөн байна.

II.11.МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛЭЭР

МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО,СУМААР,

СҮҮЛИЙН ДӨРВӨН ЖИЛЭЭР

Хүснэгт 31

Сумын нэр	Малтай өрхийн тоо				Малчин өрхийн тоо			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Дархан	817	774	808	840	308	283	345	387
Хонгор	802	776	802	806	491	476	490	581
Орхон	421	434	445	463	224	199	207	259
Шарын гол	427	424	446	422	143	142	151	144
ДҮН	2467	2408	2501	2531	1166	1100	1193	1371



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ

ДУНДАЖ ҮНЭ, ХАНШ /төгрөгөөр/

Хүснэгт 32

	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2017/2016%
Ямааны ноолуур	кг	50000	0	0	0	0.0
Адууны шир	ш	39500	42000	40000	22300	55.8
Үхрийн шир	ш	47500	39000	20000	23300	116.5
Хонины арьс	ш	2500	500	500	2200	440.0
Ямааны арьс	ш	17500	12900	21000	30000	142.9

III. ГАЗАР ТАРИАЛАН

III.1 Тариалсан талбай

Аймгийн хэмжээгээр 2017 онд нийт 22528.1 га-д тариалалт хийсэн нь 2015 оныхоос 3531.6 га-гаар буюу 18.6 хувиар буурсан байна.

2017 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл: 15064.0 га-д үр тариа, 874.1 га-д төмс, 1455.2 га-д хүнсний ногоо, 90.0 га-д малын тэжээл, 5044.8 га-д техникийн ургамал тариаллаа.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ГА

Хүснэгт 33

	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016%
Бүгд талбай	15541	18443.9	18923.9	20947.3	18996.5	22528.1	118.6
Үр тариа	9050.9	10640.5	11030.5	14660.9	11709.7	15064	128.6
Үүнээс буудай	9050.9	10640.5	11030.5	14456.9	9721.7	15064	155.0
Төмс	1189.5	695	591.2	382.8	663.9	874.1	131.7
Хүнсний ногоо	961.6	1240.5	1341.4	1023.6	1653.2	1455.2	88.0

**III.2Хураасан ургац**

Аймгийн хэмжээнд 2017 онд 11030.0 тн үр тариа, 8544.8 тн төмс, 13220.6 тн хүнсний ногоо, 162.0 тн тэжээлийн ургамал, 610.8 тн техникийн ургамал 48623.8 тн өвс хадлан, 951.6 тн таримал тэжээл бэлтгэсэн нь 2016 оныхоос Үр тариа 28.6 хувь, төмс 31.7 хувиар өсч, хүнсний ногоо 12 хувиар буурсан байна. Байгалийн өвс хадлан 19.2 хувиар буюу 11566.3 тн-оор буурсан байна.

ХУРААСАН УРГАЦ

/тн/ Хүснэгт 34

	2012	2013	2014	2015	2016	2017	2017/ 2016%
Нийт ургац	43707.7	37911.8	43787.6	14212.7	42412.1	33568.2	79.1
Үр тариа	12820.8	11698	14937	3794	18918.8	11030	58.3
Үүнээс буудай	12820.8	11698	14928	3794	18918.8	11030	58.3
Төмс	14208	8418	7327.6	2944.8	7420.5	8544.8	115.2
Хүнсний ногоо	12928.9	15277.9	17085.8	4776	14358.8	13220.6	92.1

ХУРААСАН УРГАЦ, СУМААР, ТӨРЛӨӨР

Хүснэгт 35

Сумын нэр	Үр тариа		Төмс		Хүнсний ногоо	
	Тариалсан талбай /га/	Хураасан ургац/тн/	Тариалсан талбай /га/	Хураасан ургац /тн/	Тариалсан талбай /га/	Хураасан ургац /тн/
Дархан	-	-	101.1	552.0	91.8	731.2
Хонгор	15064.0	11030.0	250.0	2560.0	151.6	1133.2
Орхон	-	-	494.0	5300.0	1205.3	11324.9
Шарын гол	-	-	29.0	132.8	6.5	31.3
ДҮН	15064.0	11030.0	874.1	8544.8	1455.2	13220.6



Хураасан ургацыг сумаар авч үзвэл Хонгор сум га-гаас 8.4 цн үр тариа, га-гаас 102.4 цн төмс, га-гаас 74.7 цн хүнсний ногоо хураан авсан нь нийт хураасан үр тарианы 100 хувь, төмсний 30.0 хувь, хүнсний ногооны 8.6 хувийг эзэлнэ. Үүний дараа Орхон сум га-гаас 107.3 цн төмс, га-аас 94.0 цн хүнсний ногоо хураан авсан нь нийт төмсний 62.0 хувийг, хүнсний ногооны 85.7 хувийг тус тус эзэлнэ. Үлдсэн хувийг бусад сумууд эзэлж байна.

МАЛЫН ӨСӨЛТӨНД ГОЛЛОН НӨЛӨӨЛСӨН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 36

	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
							%	зөрүү
Бойжуулсан төл	115756	119488	128383	138896	121495	119366	98.2	-2129
100 эхээс бойжуулсан төл	95	90	96	91	91	76	83.5	-15
Зүй бус хорогдол	2122	3426	1645	3724	1617	19075	1179.6	17458
Хээлтэгчийн тоо	129773	133821	152747	138911	155424	152988	98.4	-2436
Хээл хаясан	2997	10357	671	1622	1038	4989	4 дахин	3951
Сувайрсан	6317	2651	5364	5348	11947	14826	124.1	2879



ДҮГНЭЛТ

2017 оны мал тооллогын дүнгээр 310939 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 13224 толгой малаар буюу 4.1 хувиар өслөө. Нийт тоологдсон малын 99.0 хувийг амины мал эзэлж байна.

2017 онд аминдаа малтай 2531 өрх байгаагийн 1371 нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 2293 малчид ажиллаж байна.

Нэг малчин өрхөд дундажаар 224 толгой мал, үүний дотор адуу 12, үхэр 36, хонь 108, ямаа 67 ногдож байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн салбарт шинэчлэл хийж, ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

2017 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл: үр тариа 15064.0 га, улаан буудай 12265.2 га, төмс 874.1 га, хүнсний ногоо 1455.2 га, малын тэжээл 90.0 га, рапс 5044.8 га-д тариаллаа. Аймгийн хэмжээгээр үр тарианы тариалалт нэмэгдсэн байна. Тухайлбал: 11030.0 тн үр тариа, 8544.7 тн төмс, 13220.6 тн хүнсний ногоо, 162.0 тн тэжээлийн ургамал, 610.8 тн техникийн ургамал 48623.8 тн өвс хадлан бэлгэсэн байна.

Газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээхэн нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн үр суулгах, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх, иргэдийн дунд тариалалт хийх, ургац



хураах зэрэг асуудлаар сургалт, сурталчилгаа явуулж, мэдлэгийн дээшлүүлэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Хамгийн гол асуудал бол хөдөө орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах, борлуулах чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн цэгүүд, хадгалах, хөргөх агуулах, зоорийг бий болгох, сэргээх нь чухал байна.

Бэлчээрийн мал маллагаанд нутгийн шилмэл омог үүлдрийн малыг өөр дотор шилж сонгон цэвэр үржүүлгийн арга хэрэглэх, нутгийн үүлдэр шилмэл омгийн малаар сайжруулах төв суурин газрын хувьд сүүний чиглэлийн үхэр, адуу, тэмээ, ямааны эрчимжсэн фермерийн аж ахуй байгуулж эрхлэхийг дэмжих.

Мал сүргийг байнгын даатгалд хамруулах, байгалийн гамшиг, зудын хохиролоос сэргийлэх арга хэмжээ авах.

Малчдын боловсрол, мэргэжилтэй залуу халааг бэлтгэх арга хэмжээ авах малчин өрхийн бие даан аж ахуй эрхлэх чадавхийг бэхжүүлэх, мэдлэг олгох зайн болон танхимийн сургалтыг явуулах.

Хадлан, тэжээл үйлвэрлэлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.

Малын бэлчээр, тэжээлийн газрыг эзэмшүүлэх замаар түүний ашиглалтыг сайжруулах, хамгаалах.

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн орон нутагтаа тав тухтай ажиллаж амьдрах, хөдөлмөр нийгмийн хамгааллын баталгааг бий болгон мал аж ахуйн үйлдвэрлэл дэх ажлын байрыг хадгалах шаардлагатай.



Ашигласан ном, материал

1. Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулга -2017 он
2. Улсын Статистикийн эмхтгэл 2016 он
3. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эцсийн мэдээ
4. Дархан-Уул аймгийн Хөдөө аж ахуйн салбар, 2017 он
5. Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анх дугаар тооллого, 2012 он
6. "Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал" танилцуулга, 2017/12 сар
7. WWW.1212.mn